

УСАН ХИЛ ХАМГААЛАЛТАНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

Д. Чойбаатар.

БХУА-ийн Аюулгүй байдал стратегийн төвийн ахлах багш, доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Товч агуулга: Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн онцгой асуудлуудын нэг бөгөөд түүнийг хил залгаа орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллага хооронд хамтран шийдвэрлэж үндэсний, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажуулдаг онцлогтой. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хилийн эрх зүйн асуудлыг олон улсын 50 гаруй гэрээ, хэлэлцээрээр зохицуулж байна.

Улсын хил, хилийн дэглэмийн асуудлыг зохицуулах үйл ажиллагаа нь олон улсын гэрээ хэлэлцээрт үндэслэн хэрэгждэг. Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцууд нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс болдог.

Түлхүүр үг: Усан хил, гол, нуур, хил хамгаалалт, хилийн дэглэм

Нэг. Хилийн ус, усан хилийн талаар товч ойлголт. Монгол Улсын хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 31 дүгээр зүйлд: "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална" гэж тодорхойлсон нь усан хил хамгаалалтыг зохион байгуулах эрх зүйн үндэслэл болж байна¹. Монгол оронд 3600 орчим нуур, 3800 орчим гол, 187 орчим мөнх цас, мөс байдаг. Эдгээр нь Хойд мөсөн далайн, Номхон далайн, Төв Азийн гадагш урсгалгүй гэсэн 3 үндсэн ай савд хамрагдаж, нийтдээ 590 км.куб орчим усны нөөцтэйгээс Хөвсгөл нуур 381 км. кубыг нь эзэлдэг байна.

Монгол орны усны нийт нөөц нь дэлхийн усны нөөцийн 0.00004 хувийг, гол мөрний усны нөөцийн 1,63 %-ийг тус тус эзэлдэг байна. Усны нөөцийн 83,7 %-ийг нуур,

10,5 %-ийг мөсөн гол, 5,8 %-ийг голын ус тус тус эзэлдэг.

Гадаргын усны нөөцийн 85 %-ийг цэнгэг ус, түүний 93,6 %-ийг Хөвсгөл нуурын ус эзэлнэ. Гол мөрний жилийн дундаж урсацын 60 % нь гадагш хил даван урсах ба үлдэх хувь нь хөрсөнд нэвчиж, газрын доорх усыг тэжээх ба говийн нууруудад цутгаж ууршин шингэдэг онцлогтой.

Монгол Улсын хилийн шугамын урт 8252,6 км бөгөөд хуурай газраар 7351.6 км, усаар 901.058 км-ээр тус тус хиллэдэг. Үүнээс Оросын Холбооны Улстай 3543 км, хуурай газраар 2863 км, усаар 680 км, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 4709.6 км, хуурай газраар 4488 км, усаар 221 км хэсгээр хиллэн оршдог.

Усан хил нь Монгол Улсын нийт хилийн хэсгийн 10,9 % бөгөөд **усан хилийн 96,6 %-ийг голоор хил болгосон** хэсэг эзэлдэг. Буйр, Увс, Дөрөө нууруудаар хилийн шугам дайран өнгөрдөг. Буйр нуурын усан хил нь 30.7 км бөгөөд Монгол Улсын

¹ Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он.

усан хилийн 3.4%, БНХАУ-тай хиллэдэг хэсгийн 13,8%-ийг, Монгол

Улсын усан хилийн томоохон хэсгийг эзэлдэг.¹

Монгол Улсын хилийг хөндлөн огтолж гарсан гол, мөрөн, горхины судалгаа

Д/д	Байрлал			Ялгаа				Урсгалын чиглэл		Нийт
	Аймаг	Сум	Хилийн тэмдэг	Мөрөн	Гол	Горхи	Булаг	Орсон	Гарсан	
Монгол –Оросын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
1	8	22	33	1	55	69	-	110	15	125
Монгол –Хятадын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
2	4	9	59	*	33	8	3	23	21	44
Монгол Улсын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
3	12	31	92	1	88	77	3	133	36	169

Монгол- Оросын хилийг хөндлөн огтолж гарсан усан хилд томоохон байр суурь эзэлдэг голуудад:

Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Боршоо, Хандгайт, Улиастай, Торхилог

Завхан аймгийн Тэс, Хачиг, Цэрэг, Зос, Зайгал

Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн, Бүс, Хус, Шар гэр, Шишигт

Булган аймгийн Их Илэнгэ Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ мөрөн, Зэлтэр, Цөх, Минж, Хиагт,Бургастай

Хэнтий аймгийн Онон, Балж, Улз, Хужирт, Цагаан Чулуут, Хярхан²

Монгол- Хятадын хилийг хөндлөн огтолж гарсан усан хилд томоохон байр суурь эзэлдэг голуудад:

Баян-Өлгий аймгийн Асгат, Ёлт, Шар хамар, Харгайт, Улиастай, Ховд аймгийн Булган

Дорнод аймгийн Хэрлэн, Халх, Нөмрөг, Оршуун, Шарилж зэрэг усан хилд томоохон байр

эзэлдэг хилийн голуудыг нэрлэж болох юм.

Хоёр. Асуудлын тулгамдсан байдал

Сүүлийн жилүүдэд хилийн цагийн байдлын өрнөлт, түүний дотроос ялангуяа гол, нууртай хэсэгт хоёр талын хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй этгээдүүд үгсэн хуйвалдаж гэмт үйлдлээ хамтран хэрэгжүүлдэг хил зөрчигчдийн үйл ажиллагаа зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, орчин үеийн өндөр хүчин чадалтай техник хэрэгсэл ашиглан улсын хил зөрчих, хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт байгаа байгалийн баялгийг хууль бусаар олборлож түүгээр ашиг хонжоо олох зэрэг хэлбэрээр усан хилийн хэсгүүдээр улсын хилийг зөрчих болсон нь усан хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд үүсэж болзошгүйг харуулж, усан хилийн хамгаалалтын хэлбэр, арга тактикийг шинэчлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Монгол Улсын усан хилийн хэсгээр гарсан хилийн зөрчлийн сүүлийн 20 жилийн судалгаанд

¹ Оюунбадам. Т, Экологийн эрх зүй. 2007 он.

² Чойбаатар Д. Хилийн ус. Уб., 2022 он

дүгнэлт хийхэд гадаадаас гарсан хилийн зөрчлийн 65%-ийг Буйр нуурын усан хилийн хэсгээр гарсан

дээрхи хэлбэрийн зөрчлүүд эзэлсэн байна.

Зураг 1. Буйр нуурын усан хилийн хэсгээр гарсан хилийн зөрчлүүд



Дээрхи судалгаанаас Монгол Улсын усан хилийн томоохонд тооцогддог Буйр нуурын усан хилийн хэсэг нь хилийн цагийн байдлын өрнөлтөөр тулгамдсан асуудалд зүй ёсоор орж байгаа нь харагдаж байна.

Иймд Хил Хамгаалах Байгууллагын удирдлагаас Буйр нуурын усан хилийн хэсгийг бэхжүүлэх, хамгаалалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох асуудлыг сүүлийн жилүүдэд онцгойлон анхаарч, төрийн бодлогын түвшинд тавьж, дорвитой арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлсэнээр энэ хэсгээр гарч байсан хилийн зөрчлийг таслан зогсоосон.

Дүгнэлт

ХХБ-аас сүүлийн жилүүдэд Буйр нуурын хэсгийн усан хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээнүүд, бодит хөрөнгө оруулалтыг оновчтой, тасралтгүй хэрэгжүүлснээр усан хилийн хамгаалалтын нягтрал нэмэгдэж, найдвартай байдал хангагдаж, "Усан хил хамгаалалт дэд" хөтөлбөр" амжилттай хэрэгжиж, Буйр нуурын усан хилийн хэсгээр

гарч байсан хилийн зөрчил, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг таслан зогсоож, энэ хэсгийн усан хилийн хамгаалалт олон улсын жишигт хүрч, хилчид хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх боломтой болсон нь шинэ үеийн усан хилчдийн дүр төрхийг тодоор харуулсан, шинэ зууны хил хамгаалалтанд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүхэн ололт амжилт болсон.

Гурав: Цаашид усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь саналуудыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1.

- Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн

техник, технологийн дэвшлийг ашиглана¹.

2. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын зорилт 7.2.3.

- Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдал дээшилсэн байна².

3. Хилийн цэргийн штабаас 2023 онд баримтлах бодлого чиглэлд:

- Буйр, Увс, Дөрөө нуурын усан хил хамгаалалтанд орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлнэ
- Уулын бүсийн хилийн отрядуудын ХЗГБЧ-ийн инженерийн байгууламжуудыг нэмэгдүүлж, хяналт удирдлагын системээр тоноглоно гэсэн эрх зүйн актуудыг үндэслэн:

1. Усан хил хамгаалалтын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:

- Усан хил хамгаалалттай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчлэх
- Усан хил хамгаалалтын онол, эрх зүйн тусгайлсан гарын авлагатай болох
- Усан хил хамгаалалт хөтөлбөрүүдийг шинэчлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх

4. Усан хил хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгох чиглэлээр:

- Хилийн цэргийн штабаас уул, ой тайгын бүсийн отряд, заставуудын хариуцсан хэсэгт

мэргэжлийн бүлэг томилж, инженерийн хайгуул, газар орны туршуул явуулж усан хилийн тэмдгүүдийг шалгаж, гол, нууртай хэсгийн усан хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, боловсронгуй болгох бодомжийг боловсруулж хэрэгжүүлэх

- Буйр нуурын усан хилийг тэмдэгжүүлээгүй байгаа нь олон улсын конвенци, гэрээ, хэлэлцээрүүд зөрчигдөх, хилийн зөрчил, будлиан үүсгэх, хил зөрчигчдөд хууль бус үйлдлүүдээ гүйцэтгэх боломж олгох зэрэг олон талын сөрөг нөлөөллийг үүсгэж байгаа учраас Буйр нуурын усан хилийг тэмдэгжүүлэх асуудлыг БНХАУ-ын талтай хамтарч яаралтай шийдвэрлэх

5. Сургалт бэлтгэл, усан хилчдийг мэргэшүүлэх чиглэлээр:

- Хөгжингүй улс орнуудын усан хил хамгаалалтын арга тактикийг судлах, туршлага солилцох, усан хилчдийг сургалтанд хамруулах
- Усан хилийн мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэх сургалтын төв, дамжаа, хотхон /бассейн/ байгуулж, албаны үйл ажиллагааг бие дааж явуулах;
- Хөнгөн хөлөг, завины жолооч, засварчин, усчин аврагч, усны мэргэжилтэнг сургаж бэлтгэх
- Усан хилчидэд мэргэжлийн ур чадвар, ажлын үзүүлэлтийг харгалзан, мэргэжлийн зэрэг олгох

6. Усан хил хамгаалалтанд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх чиглэлээр:

- Усан хилийн хамгаалалтанд өндөр хүчин чадлын телекамерь, нисэгчгүй нисэх хэрэгсэл, радиолокацын станц, хяналт

¹ Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөр " Ногоон хөгжлийн бодлого " 2020 он

² "Алсын хараа-2050 " Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2020 он.

- дохиололын, дохиолол хамгаалалтын, хяналт хамгаалалтын, гэрэлтүүлэг хамгаалалтын орчин үеийн техник хэрэгсэлийг ашиглах
- Хөвөгч усан зогсоолыг усаар хиллэдэг томоохон голууд дээр буюу бусад шаардлагатай хэсэг, газар орнуудад шинээр төхөөрөмжлөх.
 - Буйр нуурын усан хилийн хэсгийг давалгаа хагалагч, эргийн бэхлэлтийн байгууламжтай болгож, дулаан мэдрэгч камер, радарын системийн хосолсон хамгаалалтад үе шаттайгаар шилжүүлэх.
 - Завь, хөнгөн хөлөг, усны мотоцикль, хөвөгч зогсоол болон техник, хэрэгсэлүүдийг хадгалах зориулалтын байруудыг барьж ашиглах.
 - Хөрш орнуудтай хамтран усаар хиллэдэг гол мөрний эргийн нуралт, идэгдэлтээс хамгаалах зорилгоор хил болгосон голуудын эргийн хамгаалалтыг мэргэжлийн байгууллагуудаар, стандартын дагуу хийлгэх
 - Булан дэрсний заставыг эрчим хүчний нэгдсэн системд холбож, хилийн төлөөлөгчийн уулзалтын цэг байгуулах
 - Хилчид үүрэг гүйцэтгэдэг томоохон голуудыг эрсдэлээс урьдчилан сэргийлж хөвөгч гүүр буюу ган татлагаар төхөөрөмжлөх.
 - Усан хилчдийг олон улсын жишигт нийцсэн шинэ загварын хувцас, аврах, хамгаалах, холбооны хэрэгсэлээр хангах
 - Голоор улсын хил болгосон хэсгийн усан хилийн хамгаалалтыг зохион байгуулдаг уулын болон ой тайгын бүсийн зарим хилийн салбаруудыг “Jetseeker” тийрэлтэт хөдөлгүүр бүхий гүехэн усны хөнгөн хөлгөөр хангах.

- Усан хил хамгаалалтын зарим анги. салбаруудыг эргүүл, хамгаалалтын зориулалт бүхий газар уснаа явагч хөнгөн хөлөг /Шинэ Зеланд улсад үйлдвэрлэгдсэн “SEALEGS 7,1M RIB”/-өөр хангах

Дүгнэлт

Дээрх цогц арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлснээр усан хилийн хэсгээр гарсан хилийн зөрчлийг таслан зогсоож, хил хамгаалалтын арга тактик шинэчлэгдэж, хил орчмын нутаг дэвсгэр, ард иргэдийн аюулгүй байдал хангагдаж, Монгол Улс дэлхийн болон олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн усан хилчидтэй болж, шинэ үеийн усан хилчдийн дүр төрхийг бий болгож, хилчид хуулиар хүлээсэн усан хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлэх бүрэн боломжтой болно гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Т. Оюунбадам " Экологийн эрх зүй " гарын авлага 2007 он
2. " Ус " үндэсний хөтөлбөр 2010 он
3. Монгол Улсын усны тухай хууль 2012 он
4. Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он
5. Д.Чойбаатар "Монгол Улсын усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь" сэдэвт докторын диссертаци 2016 он
6. Д.Чойбаатар " Усан хилийн хамгаалалт" 2017 он
7. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөр " Ногоон хөгжлийн бодлого " 2020 он
8. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2020 он
9. Д.Чойбаатар " Хилийн ус" 2022 он